



Annual Report 2021



Өөрийн цаг,
энерги, мөнгийг
чухал зүйлдээ л
зориул.

Ухаалаг зарцуул.



2021 оны үйл ажиллагааны тайлан

АГУУЛГА

Бидний анхны жил	4
Компанийн философи, алсын хараа, эрхэм зорилго	5
ТУЗ-ийн бүрэлдэхүүн	6
Компанийн бүтэц, зохион байгуулалт	7
· Менежментийн баг	8-9
· Хүний нөөц	10-11
Мэндчилгээ	13
Ярилцлага	14-15
Бизнесийн үйл ажиллагаа	
· 2021 оны тоон үзүүлэлтүүд	16-17
· Бизнесийн үйл ажиллагаа	20
· Бүтээгдэхүүний танилцуулга	21-26
· Харилцагчийн үйлчилгээний хэлтэс	27
Санхүүгийн үйл ажиллагаа	
· 2021 оны үзүүлэлтүүд	28
· Орлого, үр дүнгийн нэгдсэн тайлан /аудитлагдсан/	29
· Санхүүгийн байдлын нэгдсэн тайлан /аудитлагдсан/	30
Эрсдэлийн удирдлага	31-32
ТУЗ-ийн шийдвэр, гүйцэтгэл	33

Бидний анхны жил

Өдгөө Simple аппликэйшний таталтын тоо нь 420 мянгад хүрээд байгаа бөгөөд үүнээс 37 мянга орчим идэвхтэй хэрэглэгч байна.



Simple нь олон улсын стандартыг хангасан банк санхүүгийн хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт техник, технологи дээр суурилсан инновацилаг бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хэрэглэгчдийнхээ санхүүгийн харилцааг хялбаршуулах, зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн бүрт нийцсэн дижитал зээлийн үйлчилгээний томоохон орон зайг бий болгохоор зорьж 2020 оны арваннэгдүгээр сарын 4-нд нээлтээ хийж, үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Үүнээс ердөө нэг жилийн дотор финтекүүд дундаа дижитал зээлийн багцаараа тэргүүлсэн амжилт үзүүллээ. Түүнчлэн Simple нь Монголын топ аж ахуйн нэгж “MCS групп”-ийн 2020 оны “Шилдэг бүтээл”-ээр шалгарсан билээ.

Бид шинэлэг технологи, ухаалаг шийдлийг ашиглан хэрэглэгчдийнхээ цаг, энерги, мөнгийг хэмнэхээр зээлийн аппликэйшнийг энгийн дизайн, ойлгомжтой шийдэл, хэрэглэхэд хялбар байдлаар бүтээсэн. Simple нь олон улсын стандартыг хангасан кредит скоринг системийн тусламжтайгаар хэрэглэгчийнхээ

санхүүгийн чадварт тохирсон зээлийн хэмжээг хамгийн өндөр, хүүг хамгийн багаар санал болгодог ба дээрх бүх процессыг хүний оролцоогүй, бүрэн автоматжуулсан.

Өдгөө Simple аппликэйшний таталтын тоо нь 420 мянгад хүрээд байгаа бөгөөд үүнээс 37 мянга орчим идэвхтэй хэрэглэгч байна.

Simple нь зөвхөн зээлийн үйлчилгээ үзүүлэхээс гадна хэрэглэгчдийнхээ санхүүгийн найз байж, өөрсдийн нөөцийг ухаалаг зарцуулж, шаардлагатай үед л зээл авахыг үргэлж зөвлөдөг. Тиймээс ч хувь хүний санхүүгийн боловсролд хувь нэмэр оруулах контентуудыг тогтмол хүргэдэг.



Бидний философи

Өөрийн цаг, энерги, мөнгийг чухал зүйлдээ л зориул.



Алсын хараа

Тэргүүлэгч дижитал зээлийн платформ



Эрхэм зорилго

Харилцагчдынхаа цаг, энерги, мөнгийг хэмнэхэд зориулсан санхүүгийн хэрэгсэл байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн



Л.Соронзонболд

ТУЗ-ийн дарга



Л.Гантөмөр

*"М-Си-Эс Холдинг" ХХК-ийн
Гүйцэтгэх захирал*



Г.Мягмаржав


*"М-Си-Эс Инвестмент" ХХК-ийн
Гүйцэтгэх захирал*



Б.Билигүүн

*М-Си-Эс Группийн
Дэд ерөнхийлөгч*

Компанийн бүтэц, зохион байгуулалт



Менежментийн баг



**Гүйцэтгэх
захирал**

Б.Тэмүүлэн



**Эрсдэлийн удирдлагын
хэлтсийн захирал**

Б.Сансар



**Мэдээллийн технологийн
хэлтсийн захирал**

Н.Батжаргал



**Маркетингийн
хэлтсийн захирал**

Г.Энхмандах



**Бизнес хөгжлийн
ахлах менежер**

У.Эгшиг



**НББ-ийн ахлах
мэргэжилтэн**

Г.Мөнхбаясгалан

Менежментийн баг



**Борлуулалтын
хэлтсийн захирал**

Б.Зулзаяа



**Бизнесийн зээлийн
албаны менежер**

Л.Болор-Эрдэнэ



**Захиргаа, хүний
нөөцийн ахлах менежер**

С.Янжмаа

Хүний нөөц

Компанийн эрхэм зорилго, үнэт зүйлс, баримтлах зарчимд тулгуурлан шударга ёс, жөндөрийн тэгш эрхийг хангасан нээлттэй бодлогыг баримтлан, Монгол Улсын хуулийн дагуу ажиллана.



106

Үндсэн ажилтан



29,9

Дундаж нас



Дээд

Боловсролын түвшин



58

Эрэгтэй



48

Эмэгтэй

Бидний араншин

Бид олон ургалч, ялгаатай байдлыг хүндэлж, бүх ажилтнуудтайгаа эн тэнцүү харьцаж, хүн нэг бүрийн хүчин зүтгэл, оролцоог дэмждэг. Шинэ цагийн хөгжил, технологийн дэвшил, дэлхийн чиг хандлагатай хөл нийлүүлэн, тасралтгүй хөгжиж, бие биенээсээ суралцаж, мэдлэг чадвараа ахиулах боломжийг ажилтнууддаа олгохыг зорин ажиллаж байна.

ИТГЭЛ ДААДАГ



Бид зөвийг эрхэмлэдэг
Бид нууцыг найдвартай хадгалдаг
Бид бие биендээ бүрэн итгэдэг
Бид хэлсэн л бол хийдэг
Бид хуулийг дээдэлдэг



Араншин

НЭЭЛТТЭЙ НЭГ ХЭЛЭЭР ХАРИЛЦДАГ



Бид инээмсэглэн мэндэлдэг
Бид сонсдог
Бид харилцан хүндэлдэг
Бид бие биенээ дэмждэг
Бид ондоошлыг дэмждэг (WE ENCOURAGE DIVERSITY)



Араншин

ХАЙР ЯЛНА



Бид хайр түгээдэг
Бид эерэг хандлагатай
Бид урам зоригоор тэтгэдэг
Бид бие, сэтгэлийн эрүүл мэнддээ анхаардаг
Харилцагч бүр бидний найз



Араншин

ЯАГААД БОЛОХГҮЙ ГЭЖ...?




Бид галзуу залуус
Бид инновациар амьсгалдаг
Бид чиг хандлагыг (трендийг) тогтоодог



Араншин

ТУЛТАЛ НЬ ХИЙДЭГ



Бид 100%/100%
Бид өөриймсөг, уян хатан ажилладаг
Бид хурд, чанарыг эрхэмлэдэг



Араншин

ЗОГСОЛТГҮЙ СУРАЛЦДАГ




Бид сониуч
Бид алдахаас айдаггүй
Бид алдаанаасаа суралцдаг
Бид мэдлэгээ хуваалцдаг



Араншин

Байгаа газраасаа зээлийн эрхээ шалга



Мэндчилгээ



Simple дэх найзууд нь анхны жилээ финтекүүд дотроо дижитал зээлийн багцаараа тэргүүлсэн амжилттай үдлээ.

Л.Соронзонболд
ТУЗ-ийн дарга

Хүндэт Simple-чүүд, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, биднийг үргэлж дэмждэг бизнесийн түнш, хамтран ажиллагч байгууллагууддаа 2021 оны санхүү, үйл ажиллагааны тайланг танилцуулж байна.

Хэрэглэгчдийнхээ цаг, мөнгө, энергийг хэмнэхийг үргэлж зорьдог, “Ухаалаг зарцуул” уриатай Simple брэнд үйл ажиллагаагаа эхлүүлээд удалгүй Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотой эдийн засаг, нийгмийн хүндхэн үеүдтэй тулгарсан ч шаардлагатай арга хэмжээ, төлөвлөгөөг цаг алдалгүй хэрэгжүүлж 2021 оныг амжилт дүүрэн үдэж чадлаа.

Бид 2021 онд үйл ажиллагааныхаа хүрээг тэлж, орон нутагт гэрээ байгуулж, улмаар орон нутгийн хэрэглэгчид Simple-ийн үйлчилгээг авах боломж нээгдсэнд баяртай байна. Түүнчлэн бид хэрэглэгчиддээ зориулан дижитал зээлийн дээд

хэмжээг 20 сая төгрөг болгон нэмж, хүүг 1.7 хувь болгон бууруулж, Simple 2.0 шинэчлэлийн хүрээнд автомашин, бизнес, худалдан авалтын зээлийн бүтээгдэхүүнийг амжилттай нэвтрүүлсэн.

Simple дэх найзууд нь 2021 онд нэг жилийн ойгоо финтекүүд дотроо дижитал зээлийн багцаараа тэргүүлсэн амжилттай үдсэн нь бидний хувьд чухал үйл явдал боллоо. Ирэх жилдээ ч энэ амжилтаа улам ахиулан, хэрэглэгчиддээ зориулсан уян хатан бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлж, нийгмийн хариуцлагын хүрээнд улс орны хөгжилд хувь нэмэр оруулсан олон ажлыг хийж хэрэгжүүлэхийг зорин ажиллах болно.

Бидэнд үргэлж итгэн, дэмждэг та бүхэнд баярлалаа.

Ярилцлага



Бидний өдөр тутам хийж буй ажил, гаргаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ эцэстээ хэрэглэгчийнхээ цаг, энерги, мөнгийг хэмнэхэд чиглэдэг.

Б.Тэмүүлэн
Гүйцэтгэх захирал

Сүүлийн үед финтек компаниуд болон тэдгээрийн хэрэглэгчдийн тоо нэмэгдсээр байна. Simple-ийн хувьд бусад ижил төрлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудаас юугаараа илүү онцлог вэ, Яагаад хэрэглэгч бусад зээлийн платформыг биш Simple-ийг сонгох ёстой вэ?

Манай улсад гэлтгүй дэлхийд финтек салбар хүчээ авч, улам бүр өргөжин тэлсээр байна. Simple нь өөрсдийн хөгжүүлсэн кредит скорингийн системээрээ харилцагчийг үнэлээд тухайн хүний потенциалд тааруулж зээлийн хэмжээ, нөхцөлийг хамгийн таатайгаар бодож гаргадаг.

Бид ДАН системийг ашиглан гуравдагч байгууллагаас мэдээллээ татаж, харилцагчдаас аль болох бага мэдээлэл авдаг нь бидний давуу тал. Түүнээс гадна манай зээлийн нөхцөл, дээд хэмжээ, хүүний түвшин бусад финтектэй харьцуулбал харьцангуй таатай. Тухайлбал, хэрэглэгч аль нэг зээлийн аппликэйшнд бүртгүүлээ гэж бодоход зээлийн эрхээ эргэн төлөлт, эсвэл ямар нэг оноо цуглуулж байж нэмдэг. Энэ нь нэг талаар тухайн хүн өөрийн хүссэн хэмжээний зээлийг авахын тулд нэг дор олон аппликэйшнээс зээл авч, өрийн дарамтаа ихэсгэх эрсдэл дагуулж буй.

Харин Simple нь тухайн хүнийн потенциалд таарсан зээлийн эрхийг нь тултал нь, нэг дор өгч хэрэглэгчийнхээ цаг, энерги, мөнгийг хэмнэхийг зорьдог. Мөн бид хэрэглэгчдийгээ зээл авахыг бус, зөвхөн өөрт шаардлагатай үедээ л зээл авч, авсан зээлээ ухаалаг зарцуулахыг үргэлж уриалдаг.

Simple-ийн баг, хамт олны гол үнэт зүйл, баримталдаг зарчим юу вэ?

Манай баг 100 гаруй гишүүдтэй. Simple нь хэрэглэгчийнхээ цаг, энерги, мөнгийг хэмнэж, санхүүгийн найз нь байхыг эрхэмлэдэг тул бидний өдөр тутам хийж буй ажил, гаргаж буй бүтээгдэхүүн үйлчилгээ эцэстээ хэрэглэгчийнхээ дээрх гурван нөөцийг хэмнэхэд чиглэдэг.

Мөн IT, финтек салбар гэдэг утгаараа зогсолтгүй

суралцаж, бүх бүтээгдэхүүн үйлчилгээндээ инновацлаг байдлыг шингээж, хэрэглэгчидтэйгээ нөхөрсөг, найрсаг хандан, хийж буй ажлаа тултал нь хийхийг зорьдог.

Монгол Улсын эдийн засагт 2021 он цар тахлын нөлөө хамгийн хүчтэй мэдрэгдсэн жил байлаа. Энэ хугацаанд Simple ямар сорилтуудтай тулгарсан бэ, үүнийг давахын тулд ямар шийдлүүд боловсруулав. Нөгөө талаас цар тахал дижитал зээлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад ямар боломжуудыг бий болгов, тэрийг хэрхэн олж харж, өөрсдийн боломж болгон ашигласан бэ?

Simple нь 2020 оны арваннэгдүгээр сарын 4-нд албан ёсоор үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Энэ хугацаанд хэд хэдэн хөл хорио давхацсан ч бидний үйлчилгээ хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцэж, ойр байж чаддаг зээлийн аппликэйшн болж чадсан. Цар тахлын нөлөөгөөр бидний өдөр тутмын амьдралд дижитал бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэгцээ, шаардлага ямар их вэ гэдэг нь харагдсан. Хэн илүү хэрэглэгчдэд өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээг төгс хувилбараар хүргэж чадаж байгаа нь тэдний анхаарлыг татаж, сонгох шалтгаан болсон нь энэхүү талбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа бүхий л компаниудад эерэгээр нөлөөлсөн.

Энэ хугацаанд бид байнгын хөгжүүлэлт хийж, өөрчлөлт шинэчлэлтийн ажлаа зогсолтгүй явуулж ирсэн. Онцолбол, бид UB Cab-тай хамтарч зээлийн гэрээг хүргэлтээр, зайнаас шийдэж байлаа. Байгууллагын зээл хүсэгч зайнаас бичиг баримтаа бүрдүүлж богино хугацаанд зээлийн асуудлаа шийдүүлэх гэх мэт шийдлүүдийг гарган ажилласан.

Бидний хувьд аппликэйшнээрээ зайнаас хэрэглэгчийнхээ санхүүгийн асуудлыг шийдэж чадсанаараа цар тахал гарсан энэ хэцүү нөхцөлд харилцагчдад ч, бидэнд ч давуу талууд бий болсон.

Simple-ийн 2021 оныг тодорхойлох чухал гурван үйл явдлыг нэрлээч?

Нэгдүгээрт, 2021 оны төгсгөлд Simple брэнд нээлтээ хийгээд нэг жил болсон нь өөрөө маш онцлох үйл явдал болсон. Жилийн хугацаанд манай аппликэйшн 420 гаруй мянган таталттай болсон нь бидний хувьд төсөөлөөгүй байсан том амжилт.

Хоёрдугаарт, бид Монголын тэргүүлэгч аж ахуйн нэгж MCS групп дотроо шилдэг шинэ бүтээлийн

шагналтан болсон.

Гуравдугаарт, хамгийн чухал нь бид ердөө нэгхэн жилийн дотор дижитал зээлийн багцаараа финтекүүд дундаа тэргүүлсэн нь том амжилт.

Simple-ийн хэрэглэгчид өссөөр байна, үнэнч хэрэглэгчийг бий болгож буй гол үнэ цэнийг юу гэж харж байна вэ?

Бид бусад финтекүүдээс ялгаатай тал нь хэрэглэгчиддээ зөвхөн зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ санал болгодоггүй. Хувь хүний санхүүгийн боловсрол, сахилга батад ихээхэн анхаарч зээлийг ухаалаг зарцуулах, удирдах зөвлөгөө, контентыг тогтмол хүргэдэг. Үүгээр зогсохгүй Simple-ийн үнэнч хэрэглэгчид, коммунити дээр бид илүү анхаарал хандуулж байгаа.

Өнөөдрийг хүртэл Simple ашиглан дижитал зээлийн үйлчилгээ авахад нь гарч байгаа саад бэрхшээлд нь тусалж, асуудлыг шийдэх хэмжээнд байсан бол цаашдаа илүү ойртож хоорондоо туршлагаа хуваалцдаг, бүтээгдэхүүн үйлчилгээндээ саналыг нь сонсдог, илүү уялдаа холбоотой байхад чиглэх олон ажлуудыг төлөвлөөд байна.

Финтек компаниуд олноор гарч ирснээс хойш ямар өөрчлөлтүүдийг авч ирсэн бэ? Үүнтэй холбоотойгоор хэрэглэгчдэд том өөрчлөлтүүд гарсан уу?

Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан дүгнэлтээр манай улсад 28 финтек компани үйл ажиллагаа явуулж байна. 2020 онд нийт 1 сая зээлийн аппликэйшн хэрэглэгч байна гэсэн судалгаа байсан бол 2021 онд энэ тоо 1.7 сая болж өссөн байгаа юм. Тэгэхээр энэ бол маш том үсрэнгүй өөрчлөлт, хөгжил.

Ирэх жилүүдэд Simple-ийн хийхээр төлөвлөж буй томоохон ажлууд юу байгаа вэ?

Мэдээж финтек салбар гэдэг утгаараа бид тасралтгүй сайжирсаар байх болно. Мөн одоо байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээгээ дараагийн шатанд хүргэх зорилт тавьсан байгаа бөгөөд өөр олон шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргахаар төлөвлөөд, ажлууд маань эхэлчихсэн явж байна. ■

2021 оны онцлох үйл явдлууд



Харилцагчдын сэтгэгдэл



Ш.Мөнх-Эрдэнэ

Тулсан үед хэрэг болдог шүү.
Амжилт хүсье.



Бүрэлжин Бүрэлжин

Шуурхай, найдвартай
Simple-дээ хайртай, Амжилт.



2021.07

Simple buy болон
Маркетплейс үйлчилгээг
зах зээлд танилцуулав.



2021.09

Юнителтэй хамтарсан
утасны лизингийн
бүтээгдэхүүн гаргав.



2021.10

Тоон гарын үсэг ашиглан
зайнаас гэрээ хийх
боломжтой болов.



2021.06

Дижитал зээлийн
багцаараа
тэргүүлж эхлэв.



2021.08

Зайнаас бичиг баримт
бүрдүүлэлт хийх
боломжтой болов.



2021.10

Shoppu.mn-тэй хамтарсан
“Simple buy” зээлийн
бүтээгдэхүүн гаргав.



Tse Uran

Ёстой амар апп шүү.
Амжилт хүсье Simple.



Б.Гэрэлт-Од

Simple шиг хурдан, шуурхай газар
хаа ч мэдэхгүй юм даа.
Баярлалаа, Simple амжилт хүсье.



Ухаалаг
зарцуул

Байгаа газраасаа

зээлийн эрхээ шалга.



QR кодыг уншуулж
апп-аа татаарай.



simple.mn

#БиднийХайртайБизнес



simple | business



Хүү Урьдчилгаа


Simple өөсгөлөн Юнителээс ухаалаг
утас авах боломжтой болжээ!

Юнител-ийн урьдчилсан
төлбөрт хэрэглэгчид,
11/04-с өмнө авбал

200,000₮

Galaxy A52
1,188,000₮

Galaxy A72
1,588,000₮



Амжилттай
Таны нээх өгөгдөл.

simple | Үнэмлэг
зарцуул

Дижитал зээлийн үйлчилгээг нүд ирмэхийн зуур.

Зээлийн эрх
6'740'000
Зээлийн хүү
1.7%

Зээлийн эрх
8'500'000
Зээлийн хүү
1.9%

Зээлийн эрх
9'250'000
Зээлийн хүү
1.7%

Зээлийн эрх
10'000'000
Зээлийн хүү
1.7%

Зээлийн эрх
7'400'000
Зээлийн хүү
1.8%

Зээлийн эрх
10'000'000
Зээлийн хүү
1.7%

simple

Ухаалаг
зарцуул

Зээл авах



ӨӨРТӨӨ

Гүнзгий амьсгалаад, түр амсхийе



happy anniversary



#ДурсамжааБүтээ



20

Зээлийн апп-аа цөөл.



Бизнесийн үйл ажиллагаа

2021 оны үзүүлэлтүүд

Зээл авсан харилцагчийн тоо	36,961
Олгосон зээлийн тоо	208,115
Олгосон зээлийн хэмжээ	₮232,008,130,876
Зээлийн багц	₮116,088,507,480
Шинээр гэрээ байгуулсан харилцагчийн тоо	36,646

Зээлийн үйл ажиллагаа

Улаанбаатар, зээлийн тоо	160,393
Орон нутаг, зээлийн тоо	47,722

Дижитал зээл

Байгаа газраасаа хамгийн уян хатан нөхцөлтэй 20 хүртэлх сая төгрөгийн зээлийг нүд ирмэхийн зуур авах боломжтой. Simple нь зээл авах процесс, зарцуулах хугацааг багасгаж таны потенциалд таарах хамгийн дээд хэмжээгээр зээлийг санал болгодог. Ганц удаа гэрээ байгуулаад гар утсаараа хүссэн үедээ зээл авах боломжтой.



Дижитал зээл



Зээл олголтын хэмжээ, мөнгөн дүнгээр

₮206,951,315,218

Давуу тал

- Хаанаас ч бүрэн дижитал хэлбэрээр зээлийн дээд хэмжээгээ урьдчилж шалгах боломжтой.
- Зөвхөн ашигласан өдрөөр зээлийн хүү бодогдоно.
- Манай кредит скоринг систем сар бүр таны зээлийн эрхийг шинээр тооцоолох ба харилцагчийг хэт өндөр зээл авч өрийн дарамтад унах эрсдэлээс сэргийлдэг.

Бизнесийн зээл

Бидний амьдралын мөч бүрийг хамт бүтээлцэж, танд эрч хүч, урам зориг хайрлаж, халуун дулаан мэдрэмж төрүүлдэг бизнесүүдээ дэмжихээр уян хатан нөхцөлтэй Бизнесийн зээлийн үйлчилгээг гаргасан. Бизнес зээл авахын тулд банкинд дугаарлах шаардлагагүй, байгаа газраасаа simple.mn/business хаягаар орж зээлийн хүсэлтээ илгээх боломжтой.

#БиднийХайртайБизнес



Бизнесийн зээл



Зээл олголтын хэмжээ мөнгөн дүнгээр

₮21,223,752,700

Давуу тал

- Simple.mn хаягаар орж зээлийн дүнгээ урьдчилж шалгах боломжтой.
- Ажлын 1–3 хоногт шуурхай шийдвэрлэнэ.
- Та зээлийн хүсэлтээ л өгөхөд манай мэргэжилтнүүд очиж үйлчилгээ үзүүлнэ.
- Simple аппликэйшнээр зээлийн мэдээллээ харж, эргэн төлөлтөө хийнэ.

Автомашины зээл

Та Simple аппликэйшнээр автомашины зээлийн эрхээ урьдчилж шалгаад, хуучин эсвэл шинэ хүссэн машинаа хамгийн уян хатан нөхцөлөөр сонгож авах боломжтой.



Автомашины зээл



Зээл олголтын хэмжээ, мөнгөн дүнгээр

₮3,498,081,550

Давуу тал

- Зээлийн эрхээ урьдчилж мэдэх боломжтой.
- Ажлын 2-8 цагт шийдвэрлэнэ.
- Хүү бага, хугацаа урт.
- Эхний 3 хүртэлх сар үндсэн төлбөрөөс чөлөөлөх боломжтой.

Marketplace

Өдөр тутмын бус хааяа хийдэг өндөр дүнтэй, чухал худалдан авалтаа Simple-н Marketplace-ээр шийдээрэй. Ганц бараа бүтээгдэхүүнээр хязгаарлагдахгүй аялал, эрүүл мэнд, боловсрол зэрэг чухал үйлчилгээг онлайн орчинд зээлээр шийдэх боломжтой. Marketplace цэсэд нийт 69 мерчантын 10,000 гаруй нэр төрлийн бараа, үйлчилгээ төвлөрсөн.

Marketplace










Зээл олголтын хэмжээ мөнгөн дүнгээр

₮334,981,408









Давуу тал

- Одоо аваад 30 хоногийн дотор хүүгүй, шимтгэлгүй эргэн төлөх.
- Хүүгүй, шимтгэлгүйгээр 4 эсвэл 6 хувааж эргэн төлөх.
- 24 сар хүртэлх хугацаатай лизингээр хүссэн бараа, бүтээгдэхүүнээ худалдан авах.



Simple Зөвлөх

Simple зөвхөн шаардлагатай үедээ л зээл авахыг хэрэглэгчиддээ зөвлөдөг. Хэрэглэгч аппликэйшний зөвлөх цэсээр санхүүгийн байгууллагуудад бүртгэлтэй бүх зээлээ нэг дор харж өр орлогын харьцаагаа шалгах боломжтой. Мөн санхүүгийн мэдээлэл, контент хэсгийг багтаасан тул зөвлөх хэсгээс өөрийн санхүүгийн мэдлэгээ тэлээрэй.



Харилцагчийн мэдээллийн төв

Харилцагч нартай **1800-2828** тусгай дугаар, и-мэйл, фэйсбүүк пост, коммент, чатаар холбогдон тэднээс ирсэн зээлийн үйлчилгээ, аппликэйшн ашиглалт, бусад үйлчилгээний лавлагааг амжилттай үзүүлж асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна.



45,776

Амжилттай үйлчилгээ
үзүүлсэн байдал



89,100

Social сувгаар
үйлчилсэн байдал



5,664

Мессежээр
үйлчилсэн



2,450

И-мэйлээр
үйлчилсэн



89,100

IVR мэдээлэл
авсан



1:54

Ярианы дундаж
минут

Санхүүгийн үйл ажиллагаа

Санхүүгийн үзүүлэлтүүд

/Мянган төгрөг/

2021

Нийт актив	129,754,908
------------	-------------

Зээлийн багц	116,088,507
--------------	-------------

Нийт орлого	12,927,051
-------------	------------

Цэвэр ашиг	223,848
------------	---------

Нийт актив, пассив	129,754,908
--------------------	-------------

Өөрийн хөрөнгийн өгөөж	0.3%
------------------------	------

Санхүүгийн үйл ажиллагаа

Орлого, үр дүн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

Мянган төгрөгөөр	2021	2020
Хүү болон түүнтэй адилтгах орлого	12,927,051	483,170
Хүүгийн зардал	(3,614,116)	(6,419)
Цэвэр хүү болон түүнтэй адилтгах орлого	9,312,935	476,751
Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал	(1,370,563)	(105,785)
Үйл ажиллагааны цэвэр орлого	7,942,372	370,966
Удирдлага, захиргааны зардал	(7,564,685)	(2,705,919)
Үйл ажиллагааны бусад орлого (зардал)	(17,336)	261,662
Татварын өмнөх алдагдал	360,351	(2,073,291)
Орлогын албан татварын зардал	(136,503)	190,596
Тайлант хугацааны цэвэр алдагдал	223,848	(1,882,695)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Орлого, үр дүн рүү ангилагдсан эсвэл ангилагдах боломжтой зүйлс:	-	-
Орлого, үр дүн рүү ангилагдахгүй зүйлс:	-	-
Холбогдох татвар	-	-
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй алдагдал	223,848	(1,882,695)

Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	2021	2020
ХӨРӨНГӨ		
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
Үндсэн хөрөнгө	42,782	7,613
Биет бус хөрөнгө	556,379	618,721
Ашиглах эрхтэй хөрөнгө	334,483	112,206
Хойшлогдсон татварын хөрөнгө	165,123	205,091
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН	1,098,767	943,631
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
Бараа материал	27,507	3,832
Зээлийн авлага	114,662,025	6,393,364
Худалдааны болон бусад авлага	1,338,563	142,795
Урьдчилж төлсөн төлбөр ба урьдчилгаа	599,934	37,487
Богино хугацаат хөрөнгө оруулалт	95,155	-
Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө	11,932,957	31,095,263
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН	128,656,141	37,672,741
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	129,754,908	38,616,372
ЭЗДИЙН ӨМЧ		
Хувь нийлүүлсэн хөрөнгө	55,000,000	40,000,000
Хуримтлагдсан алдагдал	(1,658,847)	(1,882,695)
ЭЗДИЙН ӨМЧ	53,341,153	38,117,305
ӨР ТӨЛБӨР		
Зээлийн өр төлбөр	74,964,527	-
Санхүүгийн түрээсийн өглөг	-	48,254
Урт хугацаат өр төлбөрийн нийт дүн	74,964,527	48,254
Худалдааны болон бусад өглөг		
Санхүүгийн түрээсийн өглөг	1,067,964	377,422
Орлогын татварын өглөг	343,928	65,547
Орлогын татварын өглөг	37,336	7,844
Богино хугацаат өр төлбөрийн нийт дүн	1,449,228	450,813
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	76,413,755	499,067
ЭЗДИЙН ӨМЧ, ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	129,754,908	38,616,372

Эрсдэлийн удирдлага

2021 оны тавдугаар сард Эрсдэлийн удирдлагын хорооны хурлаар үйл ажиллагаандаа баримтлах Эрсдэлийн удирдлагын бодлогыг баталсан. Тус бодлогын зорилт нь бизнест ээлтэй, зохистой эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, эрсдэлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих, хэрэгжилтийг хангуулах, хяналт, тайлагналтын тэнцвэртэй тогтолцоог бий болгоход оршино.

Эрсдэлийн удирдлагын засаглал

Эрсдэлийн удирдлагын засаглал нь дараах бүрэлдэхүүнтэй байна.


- Хамгаалалтын гурван бүсийн зарчим нь эрсдэлийг зохистой түвшинд удирдах чиг үүргүүдийг тодорхойлно;
- Эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийн удирдлагын тогтолцоо, эрсдэлийн цар хүрээ, хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг тодорхойлж, батлах, түүний хэрэгжилт, биелэлтэд хяналт тавьж ажиллана;
- Зээлийн удирдлагын хороо нь зээлийн судалгаа, шинжилгээ, дүгнэлтэд үндэслэж шийдвэр гаргах, зээлийн бүтцийг өөрчлөх, барьцаа хөрөнгөтэй холбогдох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
- Эрсдэлийн удирдлагын баримт бичгүүд нь хамгаалалтын гурван бүсийн зарчмыг хэрэгжүүлэх баримт бичгүүд бөгөөд эрсдэлийн удирдлага болон түүнд тавигдах хяналтыг тодорхойлсон байна.



Хамгаалалтын гурван бүсийн зарчим

“Ашид Капитал ББСБ” ХХК нь эрсдэлийн удирдлага болон хяналтын тогтолцоондоо хамгаалалтын гурван бүсийн зарчмыг мөрдлөг болгон ажиллана.

- Хамгаалалтын нэгдүгээр бүс нь эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж ажиллах бөгөөд өөрийн бизнесийн үйл ажиллагааны хүрээнд холбогдох бодлого, журам зааврыг хэрэгжүүлэх, эрсдэлийг үнэлэх, хянах, тайлагнах, бууруулж ажиллах чиг үүрэгтэй;
- Хамгаалалтын хоёрдугаар бүс нь эрсдэлийн удирдлагын хяналтыг хэрэгжүүлж ажиллах бөгөөд байгууллагын эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог тодорхойлох, эрсдэлийн бодлого журам зааврыг боловсруулах, шинэчлэх, учирч болох эрсдэлийн төрлүүдийг тодорхойлох, тэдгээрийн хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг тогтоох, түүнийг батлуулах, хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах чиг үүрэгтэй;
- Хамгаалалтын гуравдугаар бүс нь хамгаалалтын нэг болон хоёрдугаар бүс эрсдэлийг хэрхэн үр дүнтэй удирдаж байгаа үйл ажиллагаанд хараат бус үнэлэлт дүгнэлт өгч, ТУЗ-д шууд тайлагнан ажиллах чиг үүрэгтэй.



Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээ

Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээг санхүүгийн эрсдэлийн 17 үзүүлэлт, санхүүгийн бус эрсдэлийн 12 үзүүлэлтээр хэмжин, тогтмол хянан ажиллаж байна. Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг жилд нэгээс багагүй удаа санхүүгийн төсөв, төлөвлөлт батлагдахаас өмнө шаардлагатай өөрчлөлт, тохируулгыг хийдэг. Эрсдэлийн удирдлагын нэгж нь эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээ орох өөрчлөлтийн саналыг бэлдэх бөгөөд түүнд холбогдох нэгжүүдийн саналыг тусгаж, Эрсдэлийн удирдлагын хорооны хуралд танилцуулдаг байна. Хороо нь эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээнд орох өөрчлөлтийг батална.

Эрсдэлийн төрөл		Эрсдэлийн үзүүлэлтүүдийн тоо
Санхүүгийн эрсдэл 17	Зээлийн эрсдэл	4
	Зээлийн төвлөрлийн эрсдэл	8
	Зах зээлийн эрсдэл	2
	Өөрийн хөрөнгийн хүрэлцээний эрсдэл	2
	Хөрвөх чадварын эрсдэл	1
Санхүүгийн бус эрсдэл 12	Үйл ажиллагааны эрсдэл	4
	Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл	3
	Ёс зүйн эрсдэл	3
	Хянан нийцүүлэлтийн эрсдэл	2

Зээлийн эрсдэлийн удирдлага

2021 онд Ашид Капитал ББСБ ХХК нь зээлийн бодлого, журмуудыг шинэчлэн боловсруулж, зээлийн үйл ажиллагааны процесс, түүнд тавигдах шаардлагыг бүрэн тодорхойлж, хамгаалалтын гурван бүсийн зарчмыг хэрэгжүүлэх, нэгжүүдийн чиг үүрэг, зээлийн эрсдэлийн удирдлага, хяналтыг сайжруулан ажиллалаа.

Түүнчлэн хугацаа хэтэрсэн зээлээс урьдчилан сэргийлэх, эргэн төлүүлэх үйл ажиллагаанд онцгой анхааран, шинэлэг арга барил, хэрэгслийг туршиж ажилласан бөгөөд хугацаа хэтэрсэн зээл дээр ажиллах хүний нөөцийг нэмэгдүүлж, тусгай активын нэгжийг шинээр үүсгэлээ. Үүний үр дүнд хугацаа хэтэрсэн зээл болон чанаргүй зээлийн харьцаа үзүүлэлт системийн дунджаас бага түвшинд байна.

Ковид-19 цар тахлын улмаас санхүүгийн хүндрэлд орж, зээлийн эргэн төлөлт нь доголдсон нийт

878 зээлдэгчийн 1.6 тэрбум төгрөгийн зээлийг хойшлуулж, гэрээний бүтцэд өөрчлөлт оруулан зээлдэгчдийг өрийн дарамтаас сэргийлж, хүлээж болох эрсдэлийг бууруулан ажиллаж байна.

Тус компани нь зээлийн үйл ажиллагаандаа зээлийн өргөдлийн скорингийн загварыг ашиглан хэрэглэгчийн эрсдэлийн түвшинг тодорхойлж, зээлжих зэрэглэлийг тогтоодог бөгөөд скорингийн загварын үр дүнг буцаан шалгах, шинэчлэн сайжруулах ажил тогтмол хийгдэж байна. Түүнчлэн зээлийн эрсдэлийг шинжлэн, зах зээлийн хэвийн болон хувийн бус орчинд тооцоолох, зээлийн эрсдэлийг үнэлэх арга, аргачлалуудыг сайжруулан ажиллаж байна.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа

Ашид Капитал ББСБ ХХК нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журмаар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэн ажилладаг.

Компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтын хөтөлбөрийг баталж, уг хөтөлбөрт хяналт тавих эрх бүхий албан тушаалтныг томилон Эрсдэлийн удирдлагын нэгжид ажиллуулдаг.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтын хөтөлбөрт хяналт тавих эрх бүхий албан тушаалтан нь сар тутам Эрсдэлийн удирдлагын хороонд холбогдох тайланг танилцуулж, шаардлагатай тохиолдолд холбогдох шийдвэрүүдийг гаргуулах замаар эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

2021 оны ТУЗ-ийн шийдвэр, даалгаварын гүйцэтгэл

	Төрөл	Хэлэлцсэн асуудал	Статус	Тодруулга
1	Шийдвэр	2021 оны төсөв, төлөвлөгөө	100%	
2	Даалгавар	2021 оны эдийн засгийн байдал муудах тохиолдолд хямралын үеийн зардалд хатуу хяналт тавьж ажиллах, шаардлагатай тохиолдолд төсөв тодотгох	N/A	Төсвийн тодотгол хийгээгүй
3	Даалгавар	Батлагдсан төсвийг Хөрөнгө оруулалтын хороонд танилцуулахад нэмэлтээр 5 жилийн хугацаагаар IRR тооцоолол бэлтгэж, хүргүүлэх	100%	
4	Шийдвэр	2021 оны хөрөнгийн эх үүсвэрийн бүтцийн өөрчлөлт (Equity 40B & Bond 60B)	100%	
5	Даалгавар	Хаалттай бонд, хоёрдогч өглөгийн нөхцөлийг "М-Си-Эс Инвестмент" ХХК-ийн Хөрөнгө оруулалтын хороонд танилцуулах, шийдвэрлүүлэх, СЗХ-ны зөвшөөрөл авах	100%	
6	Шийдвэр	2021 оны хөрөнгийн эх үүсвэрийн бүтцийн өөрчлөлт (Equity 55B & Bond 65B)	100%	
7	Даалгавар	Хувь нийлүүлсэн хөрөнгө, хоёрдогч өглөгийн нөхцөлийг "М-Си-Эс Инвестмент" ХХК-ийн Хөрөнгө оруулалтын хороонд танилцуулах, шийдвэрлүүлэх, СЗХ-ны зөвшөөрөл авах	100%	
8	Шийдвэр	Зээлийн эрсдэлийн сангаас 27.7 сая төгрөгийн зээлийг хорогдуулах	100%	
9	Даалгавар	50 тэрбум төгрөгийн хаалттай бонд татах нөхцөл, андеррайтерыг судлан танилцуулах, шийдвэрлүүлэх	100%	
10	Даалгавар	Итгэлцлийн зөвшөөрлийн процессыг судлан ТУЗ-д танилцуулах	50%	Холбогдох уулзалтууд хийгдэж байгаа
11	Даалгавар	ТУЗ-ийн хурлын төлөвлөгөө танилцуулах	100%	



📍 Сэнтрал тауэр, 1 давхар

📞 1800-2828

🌐 simple.mn

📱 SimpleMGL